

КОМПЬЮТЕРТ ТОМОГРАФИЙН  
АППАРАТ ШИНЭЭР СУУРИЛУУЛЖ БУЙ  
АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГУУДАД

Цацрагийн хамгаалалт, аюулгүй  
ажиллагааг хангуулах тухай

Эрүүл мэндийн салбарын тусламж үйлчилгээг сайжруулах, оношилгоо эмчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, төвлөрлийг сааруулах зорилтын хүрээнд Эрүүл мэндийн яам болон хувийн хэвшлийн эмнэлгүүд компьютерт томографийн аппаратыг шинээр суурилуулан оношилгоо хийх үед цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааг бүрэн хангаж ажиллах талаар Цөмийн энергийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.2 дахь заалтыг үндэслэн дараах ЗӨВЛӨМЖ-ийг хүргүүлж байна.

Компьютерт томографи суурилуулах өрөөний цацрагийн хамгаалалт нь тухайн аппаратны хүчин чадал болон ажлын ачааллаас хамаарах боловч дараах ерөнхий шаардлагууд тавигддаг. Үүнд:

1. Компьютерт томографийн аппарат ашиглан оношилгоо хийж буй аж ахуйн нэгж, байгууллага нь Цөмийн энергийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т заасны дагуу Мэргэжлийн хяналтын байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр ашиглах;

2. Оношилгооны үед үндэслэлгүйгээр аливаа шарлага үүсгэхгүй байх, шарлагын тунгийн зохистой хэмжээний хамгийн доод түвшинд байлгах, хүн ам, үүний дотор цацрагтай ажиллагчийг шарлагын тунгийн тогтоосон хязгаараас илүүгээр өртүүлэхгүй байх зарчмыг хангаж ажиллах;

3. Өрөөний хэмжээ болон бүтцийг үйлдвэрлэгчээс төлөвлөж өгсний дагуу зохион байгуулна. (Компьютерт томографийн шинжилгээ явуулах өрөө нь удирдлагын өрөөг оролцуулахгүйгээр хамгийн багадаа 24 м<sup>2</sup>-аас багагүй байх)

4. Компьютерт томографийн кабинетийг шинээр зохион байгуулахдаа байршлыг дээрээс нь ус нэвтэрч болзошгүй (бассейн, угаалга, усанд орох) өрөөний доор сонгохгүй байх, кабинетийг хүүхэд болон жирэмсэн эмэгтэй хэвтэж байгаа өрөөтэй зэрэгцээ байгуулахгүй байх;

5. Компьютерт томографийн кабинетийн суурин хамгаалалт (өвчтөн орох хаалга, удирдлагын өрөөний хана, хаалга, удирдлагын өрөөний харах цонх, шал, тааз)-ыг тухайн аппаратын хүчин чадал, байрлал, өрөөний хэмжээ зэрэгт үндэслэн гаргасан тооцооллын дагуу хийж гүйцэтгэнэ;

6. Компьютерт томографи суурилуулах өрөөний цацрагийн хамгаалалтыг бүтэн хийх ба тааз болон шалны хамгаалалтын зузааныг дээд ба доод давхрын ажилтнуудын байнга болон түр байрлах хугацаанаас хамааруулж шийдэх. (компьютерт томографийн кабинет нь хамгийн доод давхарт байрласан, эсвэл дээд давхарт тааз нь барилгын дээвэр доор байрлахаар төлөвлөсөн бол шал нь тусгай хамгаалалт шаардахгүй)

7. Шалны тооцоологдсон даах чадвар нь компьютерт томографийн аппаратны хамгийн хүнд хэсгийг угсрах боломжийг хангасан байх;

8. Шинээр баригдаж буй барилгад байрлах рентген кабинетийн агааржуулалт нь уг барилгын ерөнхий агааржуулалтын системээс тусдаа хийгдэнэ. Үйл ажиллагаа явуулж буй рентген тасгийн хувьд агаарын ерөнхий солилцооны сорох, гадагшлуулах системтэй хамт байхыг зөвшөөрөх ч энэ нь компьютерт томографийн болон халдвартын эмнэлгийн рентген кабинетад хамаарахгүй.

9. Шинжилгээний болон удирдлагын өрөөний хана, тааз нь гөлгөр, амархан цэвэрлэгддэг, чийгтэй цэвэрлэгээ хийж болохоор байна.

10. Кабинетийн шинжилгээний өрөө ба эмчилгээний кабинетийн удирдлагын өрөөний орох хаалганы дэргэд, шалнаас 1.6-1.8 м өндөрт эсвэл хаалганы дээд талд “Гэрэл ассан үед орж болохгүй” гэсэн гэрлэн дохиог байрлуулсан байх ба рентген аппаратыг залгахад автоматаар асахаар хийгдсэн байна. Гэрлэн дохион дээр цацрагийн аюулгүйн тэмдгийг тавихыг зөвшөөрдөг. Мөн стандартын дагуу хийгдсэн цацрагийн анхааруулах тэмдгийг санамжийн хамт байрлуулна.

11. Дүрс оношилгооны эмч, цацрагтай ажиллагчид нь зураг унших болон рентген оношилгоо хийхээс бусад үед байрлах тусгай өрөөтэй байна.

12. Компьютерт томографийн өрөөний хаалганы өргөн нь 1.2 м-ээс багагүй, өндөр нь 2.0 м байна.

13. Компьютерт томографийн нэмэлт газардуулгын систем нь бусад багаж хэрэгслээс ангид хийгдэх ёстой; (газардуулгын системд мэргэжлийн байгууллагаар хэмжилт, баталгаажуулалт хийлгэсэн байх)

14. Цахилгаан хангамж нь тогтвортой, хэлбэлзэлгүй байх ба цахилгааны гадны болон дотоодын нөөц эх үүсвэртэй байх;(хүчдэл тогтворжуулан барих төхөөрөмж суурилуулах)

15. Компьютерт томографийн суурилуулж буй аж ахуйн нэгж, байгууллагын холбогдох мэргэжилтнүүд мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтад хамрагдах;

**ЦӨМИЙН БОЛОН ЦАЦРАГИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ХЯНАЛТЫН ГАЗАР**